

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг
зохион байгуулах, хянан зохицуулах Үндэсний
зөвлөлийн хуралдааны тэмдэглэл /2011-11-10/**

Үндэсний зөвлөлийн ээлжит хуралдаан 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 17 цаг 30 минутад Төрийн ордны “Нутгийн удирдлагын танхим”-д эхлэв.

Хуралдаанд Монгол Улсын Ерөнхий аудитор Ч.Раднаа, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч Л.Нямсамбуу, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгор, Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн ерөнхий менежер И.Идэш, Арева Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Луузан, Оюу Толгой ХХК-ийн шинжээч Г.Жавхлантөгс, Сангийн дэд сайд Ч.Ганхуяг, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа нар оролцов. Хуралд Үндэсний зөвлөлийн 18 гишүүдээс 11 гишүүд оролцож ирц 61 хувьтай байв. Үндэсний зөвлөлийн гишүүн Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд С.Баярцогт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга Хаянхярваа нар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанд оролцож байсан тул хүрэлцэн ирээгүй болно.

Мөн хуралдаанд Ашигт малтмалын газрын дарга Д.Батхуяг, Засгийн газрын ахлах референт, ОУИТБС-ын ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумьяа, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга С.Мягмардаш, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгалийн нөөцийн газрын дарга Д.Энхбат, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын орлогч дарга Ч.Цогтбаатар, Сангийн яамны мэргэжилтэн Ж.Ивээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Уул уурхайн хэлтсийн дарга Б.Баатарцогт, Татварын ерөнхий газрын Эрдэс баялгын татварын орлогын хэлтсийн дарга Ч.Цэндмаа, Татварын ерөнхий газрын ахлах байцаагч Т.Цэцэгням, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Т.Цэгц, Д.Лхагвасүрэн, Адам Смит байгууллагын төслийн ахлах зөвлөх Жереми Уите, дотоодын зөвлөх Ч.Энхзаяа, орчуулагч Д.Ганхуяг, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн ажилтан Б.Дэлгэрмаа нар оролцов.

Хуралдааныг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгор нээж, Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе! Өнөөдрийн хурлыг удирдах ёстой Зоригт сайд маань Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанд Газрын тосны асуудал хэлэлцүүлэх болсон тул ирж чадахгүй болж байна. Явцын дунд ирж магадгүй юм. Тиймээс хурлаа эхлүүлээд явж байя. Хуралдаанаар 5 асуудал хэлэлцэнэ, та бүхэнд хуралдааны материалыг урьдчилан тараасан байгаа гээд хэлэлцэх асуудал болон хуралдааны дотоод журмыг гишүүдээс санал авч баталснаар хуралдааныг эхлүүлэв.

Б.Долгор хэлэлцэх асуудлын дарааллын дагуу 2009 оны тайланг Улаанбаатар аудит корпорацийн ерөнхий захирал Б.Осоргарав танилцуулна гэв.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Харт Нойрс лдт болон Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн гаргасан Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2009 оны аудитын нэгтгэсэн тайлан (Энэ тайланг хэлэлцэхтэй

холбогдуулан “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав, аудитор Б.Мэндбаяр, Т.Отгонхүү, Ц.Болортуяа нар хуралдаанд байв.)

Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав танилцуулгын эхэнд мэндчилээд Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны тайланг бид 2011 оны эхний хагас жилд багтаан хийж гүйцэтгээд тайланг Англи, Монгол хэлнээ бэлтгэн хэвлүүлж Үндэсний зөвлөлийн гишүүд Та бүхэнд хүргүүлсэн бөгөөд та бүхнийг хүлээн авч танилцсан байх гэж найдаж байна. За ингээд та бүхэнд Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлангийн тухай товч танилцуулгыг хийе гэв. /Танилцуулгыг хавсаргав./

Б.Долгор: За баярлалаа. Одоо энэ тайлантай холбогдуулаад зарим газруудын дүгнэлтийг сонсоно. Сангийн яамны дүгнэлтийг С.Мягмардаш гуай танилцуулна уу.

С.Мягмардаш: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. ОУИТБС-ын 4 дэх удаагийн тайлангийн талаар Сангийн яамны санал, дүгнэлтийг танилцуулахад ОУИТБС-ын 2009 оны тайланг олборлох үйлдвэрлэл эрхлэгч 363 аж ахуйн нэгж гаргасан бөгөөд эдгээр компаниуд нь улсын болон орон нутгийн төсөвт нийт 304,3 тэрбум төгрөгийн албан татвар төлжээ. 2009 оны тайлангийн нэгтгэлийг Улаанбаатар аудит корпораци ХХК болон Англи Улсын Харт Нойрс лтд нарын хамтарсан консорциум хийж гүйцэтгэсэн байх ба аудитын нэгтгэлд 50 сая төгрөгнөөс дээш татвар, төлбөр төлсөн 101 аж ахуйн нэгж хамрагджээ. Хоёр талын тайланг нэгтгэхэд 2009 онд 58,2 сая төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдсэн гэсэн аудитын дүгнэлт гарсан байх бөгөөд үүнийг 2008 оны шийдэгдээгүй үлдсэн зөрүүтэй харьцуулахад энэ нь 86,2 хувиар буурсан байна. Эндээс харахад олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа компаниудын ил тод байдал сайжирч байна гэж Сангийн яам дүгнэж байна. Тайланг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргах ажлыг хөнгөвчлөх зорилгоор Сангийн яам одоо ашиглаж байгаа мэдээллийн бааз, тайлан нэгтгэлийн И-Баланс цахим системд ОУИТБС-ын тайланг оруулж шинэчлэх, санхүүгийн тайлангийн маягтын загварыг боловсронгуй болгон түүний тодруулга хэсэгт ОУИТБС-ын мэдээллийг тусгадаг байхаар өөрчлөх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөн ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Түүнчлэн энэ удаагийн тайлангийн дүнгээс үндэслэж, Үндэсний зөвлөлөөс цаашид дараахь арга хэмжээг авах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд: 1.Тайлан гаргах талаар төв, орон нутгийн төрийн байгууллагуудын холбогдох ажилтнуудад заавар, зөвлөгөө өгөх, сургалт семинар зохион байгуулах; 2. Байгаль хамгаалах чиглэлээр тайланд шийдэгдээгүй зөрүү их байгаад дүгнэлт хийж холбогдох арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд зориуд анхааруулах; 3.Олборлох үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд заавал аудит хийж байх хууль, эрх зүйн тогтолцоог бий болгох; 4.Тайлангийн үр дүнг сурталчлах зорилгоор олон нийтэд ил тод мэдээлэх; 5.Тайлан хүлээн авах ажлын зохион байгуулалтыг сайжруулах ба тайлан гаргагч төрийн байгууллагуудын уялдааг сайжруулах ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Долгор: За баярлалаа. Одоо Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Ашигт малтмалын газарт гарсан хандивын зөрүүний талаархи шалтгаан, хийх дүгнэлтийг Ашигт малтмалын газрын дарга Д.Батхуяг танилцуулна уу.

Д.Батхуяг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. За 2009 оны тайлантай холбогдуулаад манай газраас 3 асуудал дээр тайлбар хийнэ, мөн цаашид авах арга хэмжээний талаарх саналаа танилцуулая. Нэгдүгээрт, 2009 оны тайланд манайтай холбогдон гарсан хандивын зөрүүний тухайд уг хандивыг геологийн алба байгуулагдсаны 70 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан бөгөөд Эрдэс баялаг, эрчим хүчний яаманд төвлөрөн зарцуулагдсан болно. Хоёрдугаарт, 2008 оны нэгтгэл тайланд гарсан зөрүүний шалтгааныг тодруулах зорилгоор нэгтгэлд орсон 46 аж ахуйн нэгж тус бүрийн тайланг уулын ажлын тайлантай нь тулгаж үзэхэд аж ахуйн нэгжүүд оронгийн алдаа гаргах, хэмжих нэгжээ зөрүүлэх, уулын ажлын төлөвлөгөөндөө цэврээр тоо хэмжээгээ өгчихөөд ил тод байдлын тайланд бохиороор тайлагнах зэрэг шалтгаануудаас зөрүү үүссэн байна. Гуравдугаарт, 2009 оны нэгтгэл тайланд орсон компаниудыг тулгалт хийж байна. Цаашид авах арга хэмжээний тухайд, 1.ОҮИТБС-ын эрх зүйн орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллах; 2.ОҮИТБС-ын үйл ажиллагаанд оролцож буй Засгийн газрын байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд хоорондын ажлын уялдаа холбоог эрх зүйн талаас нь зохицуулах; 3.Аж ахуйн нэгж нь ОҮИТБС-ын тайланг сайн дурын үндсэн дээр бөглөж өгдөг гэдэг ойлголт түгээмэл байгааг зогсоох, зохих зохион байгуулалтын болон хариуцлагын арга хэмжээ авах; 2008 оны нэгтгэл тайланд үүссэн шийдэгдээгүй зөрүүний мөрөөр ажиллах; 4. Тайлангийн маягтыг буруу, алдаатай бөглөх явдал их байгаа тул манай газраас ажлын албатай хамтран сургалт, семинарыг тогтмол зохион байгуулах зэрэг саналтай байна. Анхаарал тавьсанд баярлалаа. /Танилцуулгыг хавсаргав./

Б.Долгор: За баярлалаа. Одоо байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал, байгаль хамгаалах зардлын урьдчилсан төлбөрийн зөрүүний шалтгаан, дүгнэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга Д.Энхбат танилцуулна уу.

Д.Энхбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. ОҮИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлангийн байгаль хамгаалах ажиллагаанд зарцуулсан зардал, байгаль хамгаалах зардлын 50 хувийн урьдчилгаа төлбөртэй холбоотой асуудлаар танилцуулга хийгээд, саналаа тавъя. 2007 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн дагуу байгаль хамгаалах зардлын 50 хувийг барьцаа болгон тус яамны дэргэдэх төрийн сангийн тусгай дансанд байршуулдаг. 2009 онд 166 аж ахуйн нэгжийн 385 сая төгрөг байршуулсан байна. За ОҮИТБС-ын 2009 оны нэгтгэлийн тайланд орсон 101 аж ахуйн нэгжийн мэдээллээр 302 сая төгрөгийг байгаль хамгаалах тусгай дансанд төвлөрүүлсэн байна. Энэ төлбөртэй холбоотойгоор 31,7 сая төгрөгийн зөрүү үүссэн. Үүний шалтгааныг товчхон тайлбарлавал, хуулийн дагуу бол ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь яамны тусгай дансанд, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сум, дүүргийн тусгай дансанд төлбөрөө байршуулах ёстой, гэтэл хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд яамны дэргэдэх тусгай дансанд төлбөрөө байршуулснаас гол зөрүү үүссэн байгаа юм. Хоёрдугаарт, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлөө бусдад шилжүүлэхдээ байгаль хамгаалах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн эсэх, баталгааны дансанд мөнгө шилжүүлсэн эсэхээ тодорхойлуулж байж лицензээ шилжүүлдэг. Тэгэхээр энэ дагуу Ашигт малтмалын газраас тухайн талбайд үйл ажиллагаа явуулаагүй байсан ч байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд байршуулсан уу үгүй юу гэдэг дээр асуудал гарч ирдэг. Гуравдугаарт, байгаль хамгаалах зардлын 50 хувийг байршуулах сум, орон нутгийн данс нь тухайн сум орон нутгийн Засаг даргын

Тамгын газарт тодорхойгүй байгаагаас гол зөрүү үүсч байна. Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.9-т заасны дагуу тухайн аж ахуйн нэгж байгаль хамгаалах үүргээ 100 хувь биелүүлсэн тохиолдолд тухайн барьцаа хөрөнгийг буцааж олгодог. Гэтэл мэргэжлийн хяналтын байгууллагаар акт дүгнэлт гаргуулахад 100 хувийн гүйцэтгэлтэй компани нэг ч байдаггүй ба ихэвчлэн 50-60, 70 хувь байдаг тул тухайн барьцаа хөрөнгийг буцаан олгохгүйгээр дараа жил нь үргэлжлүүлэн дансанд байршуулах асуудал гардаг. Гэтэл Засгийн газар зөвхөн тухайн жилд нэмж төвлөрүүлсэн дүнг тайлагнадагаас шалтгаалаад энэ хэсэг дээр бас зөрүү үүсдэг. Зөрүү үүсдэг шалтгаануудын тухайд ийм байна. Цаашид авах арга хэмжээний саналын тухайд: 1. Аж ахуйн нэгжүүд Ашигт малтмалын газар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тухайн жилийн уулын ажлын тайланг ирүүлдэг хирнээ манай яаманд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний биелэлт, үр дүн, зарцуулсан зардлын талаарх тайлангаа ирүүлдэггүй. Үүнтэй холбоотойгоор зөрүү гарч байна. Иймд ОУИТБС-ын тайланг сайжруулахын тулд компаниудын тайланг хүлээн авдаг, хянадаг төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох, орон нутгийн төр захиргааны байгууллагуудаас холбогдох тайланг тогтмол авч нэгтгэлдээ оруулж байхад онцгой анхаарах шаардлагатай байна. 2. Манай яам 2011 оноос аж ахуйн нэгжийн байгаль орчинг хамгаалах төлөвлөгөө, орчны шинжилгээний хөтөлбөрийг хянан батлахдаа тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө, өмнө нь хийж гүйцэтгэсэн тайлантай нь тулгаж байж баталдаг болсон. Ингээд ирэхээр зөрүү гарах байдал нь эрс багасна. Түүнчлэн ижил утга бүхий 3 тайланг 3 байгууллагад өөр өөр дүнгээр тайлагнадаг байдлаас үзэхэд эдгээр 3 байгууллагын уялдаа холбоог сайжруулах, тайлангийн дүн нь адил байх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байгаа юм. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Долгор: За баярлалаа. Тайлан болон мэдээллүүдтэй холбоотой асуух асуулттай хүн байна уу?

Г.Уранцоож: Компаниуд орон нутагтай тухайн орон нутгийг хөгжүүлэх гэрээ хийдэг. Ийм гэрээ байгуулсан компаниуд байна уу? Тэр гэрээний дагуу шилжүүлсэн мөнгө төгрөг нь яаж тайлагнагдаж байна вэ?

Б.Мэндбаяр: Ихэвчлэн газрын тосны компаниуд байгаа. Шилжүүлэхдээ тухайн орон нутгийг хөгжүүлэх санд гэж хандив маягаар орж ирээд байгаа. Бид үүнийг тухайн орон нутгийн удирдлагатай холбогдож, тийм хандив хүлээн авсан эсэхийг тодорхойлсон албан бичгийг хүлээн авч тулган баталгаажуулалтаа хийж байгаа.

Н.Баярсайхан: Осоргарав гуайгаас асуух асуулт байна. Өвөрхангай аймгийн Уянга суманд жишээлбэл Баярсгоулд компанийн талбай дээр лицензгүй 60 гаруй туслан гүйцэтгэгч компаниуд нөхөн сэргээлт хийгээд явж байна. Ер нь эдгээр туслан гүйцэтгэгч компаниуд энэ ил тод байдлын тайланд хамрагддаг уу?

Б.Мэндбаяр: Одоогоор туслан гүйцэтгэгч компаниуд нэгтгэл тайланд ороогүй байна. Бид гэхдээ энэ талаар 2008, 2009 оны тайлангийн зөвлөмжиндөө туслан гүйцэтгэгч компаниудыг ил тод байдлын тайланд хамруулах нь зүйтэй юм гэж оруулсан байгаа.

Б.Осоргарав: Ер нь энэ уул уурхайн компаниуд ихэнхдээ туслан гүйцэтгэгчээр л ажлаа гүйцэтгүүлдэг юм байна. Тэгээд тухайн төлбөрийг тэр толгой компани нь ч төлж байгаа юмуу, туслан гүйцэтгэгч нь төлөөд байгаа юмуу учир нь олдохгүй ийм байдаг. Тэгээд бид тэдгээр туслан гүйцэтгэгч нарыг тайлан гаргах талаар хүсэлт тавихаар бид энэ тайланг гаргах албагүй гэсэн байдлаар ханддаг. Тиймээс энэ талаар анхаарч, их тодорхой болгох шаардлага бий.

П.Эрдэнэжаргал: 2010 оны нэгдсэн тайлангаа гаргаж байхад бид 2009 оны тайлан яриад сууж байна. Аудитын нэгтгэл дандаа 1 жилээр хоцорч явагдаж байна. Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн хүндрэл гарч байна уу? Саналаа хэлнэ үү.

Б.Осоргарав: Би энэ тухай зөвлөмжиндөө түрүүнд хэлсэн. Ер нь бол цаг хугацааны хувьд хожимдож аудит хийхээр хүндрэлтэй талууд байдаг. Тухайлбал компаниудын нягтлан нь солигдсоноос юмаа сайн мэдэхгүй байх, өмнөх оны санхүүгийн баримтууд нь архивт орсон байх, эзэн холбогдогч нь олдохгүй болчих гэх зэрэг хүндрэлүүд байдаг. Гэхдээ бид энэ хүндрэлийг давж, тайлангаа гаргасан. Одоо бид 2010 оны нэгтгэлийн ажлыг хийж байна. Харьцангуй хүндрэл бэрхшээл гайгүй байгаа. Цаашид энэ хоцорч явдаг бэрхшээл гарахгүй байх гэж найдаж байна.

Б.Долгор: За өөр асуулт байна уу? Байхгүй бол саналтай хүн байна уу?

Н.Алгаа: 2 санал байна. Нэгдүгээрт, би олон удаагийн хурал дээр яриад байгаа. Гол нь бид олборлох салбарын ил тод байдлыг хангах ийм зорилго дор ажиллаж байгаа. Гэтэл бүр жижиг жижиг төлбөрүүд, үйлчилгээний хураамжийн хойноос хүртэл хөөцөлдөх шаардлага байна уу? Заавал эдгээр төлбөр, үйлчилгээний хураамжийг ил тод байдлын тайланд оруулах хэрэг байна уу? Энэ нь эргээд бидний ажлыг удаашруулах байдал ажиглагдаад байна. Тиймээс ерөөсөө олборлох салбарын онцлогтой холбоотой гол гол татвар, төлбөр, за лицензийн хураамж зэргийг л тайландаа оруулаад явах нь зүйтэй гэсэн саналтай байна. Хоёрдугаарт, тэр туслан гүйцэтгэгчийг тайланд хамруулах талаар түрүүнд ярьлаа. Энэ дээр их сайн бодох хэрэгтэй, томоохон хэдэн туслан гүйцэтгэгчийг буюу нөөцийн төлбөрөөс хуваалцдаг тэдгээр туслан гүйцэтгэгчийг хамруулж болох юм. Түүнээс бүх туслан гүйцэтгэгчийг хамруулах гэхээр бидний нөгөө олборлох салбарын ил тод байдал халиад үйлчилгээний салбар руу орох вий.

Л.Нямсамбуу: Санаачилгын одоогийн байдлыг ажиглаад байхаар нэг талаас гайгүй яваад байгаа, үр дүнд хүрээд, төлөвшиж магадгүй гэсэн ийм өнгө төрх харагдаад байгаа- мөртлөө дотор нь яг нарийн энэ аудитын тайлангийн тухай сонсохоор бас болохгүй зүйлүүд байна. Одоо бараг 2012 он, гэтэл 2009 оны тайланг өнөөдөр хэлэлцэж байна. 2 жилийн өмнөх дутагдлыг одоо хэлэлцэж байх жишээтэй. Тэрнээс хойш юу нь сайжраад, ямар ахиц дэвшил гарсан юм гэхээр ойлгогдохгүй ийм юм байх юм. Ерөөсөө энэ тайлангаас гол анхаарал татаж буй асуудал бол компаниудаас өгч буй хандивын асуудал байна. Яагаад төсвөөс санхүүжиж буй байгууллага тэр уул уурхайн компаниас хандив авах ёстой юм, яагаад хандив өг гээд зовоогоод байдаг юм. Тийм хэрэгцээ байдаг юм бол тэр уул уурхайн компаниудаас хүлээн авсан татвараас санхүүжүүлж болно шүү дээ. Тиймээс бид нарын зүгээс, Үндэсний зөвлөлийн зүгээс энэ хандив авдаг явдлыг өөгшүүлэх бус, энийг зөвхөн тайланг нь сонсоод өнгөрөх биш, үүнийг цаашид яаж газар авахуулахгүй байх вэ гэдэг дээр анхаарч ажиллах хэрэгтэй байгаа юм. Яг тэр хандив юунд зарцуулагдаад байна вэ гэдэг нь бас тодорхойгүй. Тиймээс бид энэ

талаар маш хариуцлагатай санал гаргаж, хэлэлцмээр байна. Дараагийн нэг асуудал бол тайлан гаргахгүй байгаа, тайланг хойноос нь нэхэж гаргуулж байгаа, гаргасан тайлан нь хоорондоо зөрж байгаа, зөрүүний шалтгааныг тайлбарлахгүй байгаа гэх юм. Үүнийг энэ өнгөрсөн 3-4 жилд ерөөсөө стандарт тогтоогоод, хууль гаргаад, эрх зүйн акт тогтоогоод өдийд шийдчихэж болно шүү дээ. Яг энэ асуудлын үүднээс үзэхэд энэ санаачилгыг хэрэгжүүлэхэд энэ Үндэсний зөвлөл буюу миний, бидний хийж буй ажил хангалтгүй байна. Тэгэхээр бид жаахан хариуцлагатай хандмаар байна. За түүнчлэн аудитын байгууллага их чухал санал гаргаж байна, дээрээс нь холбогдох яам, агентлагууд дүгнэлт, саналаа хэлж байна, үүнийг бид яаж ажил хэрэг болгохоо санаачилгын 2011-2013 оны төлөвлөгөөндөө суулгаж өгмөөр байна. Тэгээд бид нар энэ асуудлыг дахиж ярихгүй байх ёстой. За тэр тайлангийн зөрүүний тухайд ерөөсөө Монголд хавтгайраад байгаа нөгөө л хариуцлагын асуудал мөн л энд гарч ирж байна, ямар ч эрх зүйн зохицуулалтгүй байна. Тэр их зөрүү гаргадаг, авсан хандивынхаа тайланг гаргадаггүй, эсхүл өөр зориулалтаар ашигласан албан тушаалтнууд ямар хариуцлага хүлээх вэ, эсхүл тэр гарцаагүй гаргах ёстой тайланг гаргаж өгөөгүй, буруу гаргасан ажилтан ямар хариуцлага хүлээх вэ гэдэг дээр зохицуулалт хийж өгч, ингээд цааш ахиад явахгүй бол энэ ажил ер олигтой явахгүй нь. Эцэст нь хэлэхэд ерөөсөө тэр хууль юмуу шаардлагатай эрх зүйн акт гаргаад энэ хэдэн байнга давтагдах гээд байгаа, давтагдаад байгаа хэдхэн асуудлыг шийдэх хэрэгтэй. Эдгээрийг л шийдэхэд энэ санаачилга цаашид хөнгөхөн явчих юм байна, магадгүй Үндэсний зөвлөл дахин дахин хуралдах шаардлагагүй болох байх гэж бодож байна.

Ч.Раднаа: Тайлангаас харахад тэрбумын зөрүү, 700 сая болоод, одоо 58 сая болтлоо буурснаас үзэхэд тоон үзүүлэлтээрээ энэ аудитын консорциумын ажил дэвшилттэй явж байна. Гэхдээ илрүүлэлтийн хувьд зөрчил гарсан, төлбөр тогтоосон, акт тавьсан гэсэн юм нэг ч харагдахгүй юм. Үүнээс үзэхэд ерөөсөө зөрчилтэй зүйл нэг ч байхгүй, хувьдаа завшсан зүйл нэг ч байхгүй, чин үнэнчээр л тэр Тамгын газартаа, тэр аймаг сумын хөгжилд зарцуулсан байгаад байх шиг байна. Тэгэхээр илрүүлэлтийн тал дээрээ нилээн анхаарч ажиллаачээ гэж хүсэх байна. Манай аудитаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн тохиолдол зөндөө л гардаг шүү дээ. Сумын сургууль дээр л аудит хийхэд хуулийн байгууллагад шилжүүлэх тохиолдол гарах жишээтэй. Гэтэл энэ олон уул уурхайн компаниудаас хандив, дэмжлэг авсан байж тэр сум, аймгийн Тамгын газарт хууль хяналтын байгууллагад шилжсэн зүйл байхгүй байна гэхээр их л үнэмшилгүй байгаад байна. Хоёрдугаарт, энэ аудитын байгууллагыг ажлаа хийхэд нь эрх зүйн талаас нарийн зохицуулалт хийж өгөх шаардлага харагдаж байна. Жишээ нь тэр компаниуд тайланг гаргаж өгөхгүй гэдэг, хэд дахин яриулдаг, явуулдаг ийм байдал ажиглагдаж байна. Тиймээс тэр зайлшгүй шаардлагатай гаргуулах зүйлсийг нь тодорхой болгоод тэр баримт, тайлан гаргаж өгдөг нөхдүүдэд сайн ойлгуулж өгөхгүй бол аудиторруудад их хүндрэлтэй байдал харагдлаа. Дээр нь Төсвийн тухай хуулийн төсөл Улсын Их Хурлаар хэлэлцэгдээд одоо эцсийн шатны хэлэлцүүлэг үлдчихээд байгаа. Энэ хуулийн дагуу төрийн болон хувийн, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс сургууль, эмнэлэг, соёлын байгууллага л хандив авч болно, бусдыг нь хорьж байгаа. Тэгэхээр энэ хандивын асуудал нилээн цэгцрэх байх. Энэ мэтчилэн эрх зүйн талаас шаардлагатай зохицуулалтуудыг хийгээд өгчихвөл дэвшилттэй зүйл нилээн гарах байх гэж бодож байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Долгор: Асуудлыг шийдвэрлэхээс өмнө Раднаа даргаас асуух зүйл байна. Өнөөдрийн хуралдааны шийдвэрийн төсөл дээр шийдэгдээгүй үлдсэн 58,2 саяыг

Үндэсний аудитын газраар шалгуулах гэж байгаа. Энийг ийм маягаар томъёолох бололцоотой юу?

Ч.Раднаа: Нэгдүгээрт, одоо бол энэ 58,2 саяыг бага дүн учраас шалгах шаардлагагүй гэж үзэж байна. Хоёрдугаарт, ерөөсөө санаачилгын нөхдүүд маань тендер зарлаад, аудитын компани шалгаруулаад, өч төчнөөн сая төгрөгөө төлчихөөд шийдэгдээгүй үлдсэн зөрүү гээд нэг ажил үлдэхээр өөр компаниар шалгуулаа гэж таарахгүй. Нөгөөтэйгүүр энэ аудит хийсэн компани нь ч гэсэн бид үүнийг илрүүлж чадсангүй, үүнийг нь өөр газраар шалгуулаарай гээд суух нь зүйд нийцэхгүй. Гуравдугаарт, манайх хувийн компани дээр аудит хийх эрхгүй, боломжгүй юм.

Б.Долгор: За. Тэгэхээр энэ аудитын компани бол нэгтгэлийн тайланг л гаргах эрхтэй болохоос яг одоо төлбөрийн акт тогтоогоод, түүнийг нь хууль хяналтын байгууллагад шилжүүлэх эрх хэмжээ одоогоор байхгүй байгаа юм. Тэгэхээр энэ шийдэгдээгүй үлдсэн зөрүүний мөрөөр арга хэмжээ авах ажил нь манай санаачилгын байгууллагад оногдож байгаа, энэ тал дээр анхаарч ажиллах ёстой. Хоёрдугаарт, бидэнд одоо байгаа эрх зүйн эрх хэмжээгээ бүрэн ашиглах шаардлагатай байна. Холбогдох байгууллагууд нь холбогдох хуулийнхаа хүрээнд хариуцлага тооцох, зөрчлийг цаашид гаргуулахгүй байхад чиглэсэн ажлыг зохион байгуулахад анхаарч ажиллах хэрэгтэй. Нөгөө нэг асуудал нь эрх зүйн орчинг шинээр бий болгох, хуулийг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах нэн шаардлагатай байгаа. Хэдийгээр энэ ажлыг бид зохион байгуулсан ч төдийлөн дэмжлэг аваагүй, гэхдээ бид Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас яг энэ хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр техник туслалцаа авахаар болсон гэдгийг хэлмээр байна. Ингээд та бүхний гаргасан саналыг тусгаад шийдвэрээ гаргая.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Харт Нойрс лтд болон Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн гаргасан Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2009 оны аудитын нэгтгэсэн тайланг дэмжиж батлахаар тогтов.

2. Энэхүү тайланг Монгол Улсын ОУИТБС-ын ажлын албаны вебсайт болон Сангийн яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Монголын уул уурхайн ассоциаци, Нээлттэй нийгэм форумын вебсайтад тус тус тавьж нийтэд ил тод болгох нь зүйтэй гэж үзэв.

3. Тайланг ОУИТБС-ын олон талт оролцогчдын уулзалтаар хэлэлцүүлэхийг Үндэсний зөвлөлийн 3 талын төлөөлөл Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн Ерөнхийлөгч Д.Дамба, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал нарт үүрэг болгож, хэлэлцүүлэг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхийг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

4. 2009 оны тайланг үндэслэн хураангуй тайланг нэгтгэн гарган сурталчилж байгааг дэмжиж, энэхүү хураангуй тайланг аймаг тус бүрээр гаргаж аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлэх, цаашид энэ арга хэмжээг хэвшил болгон зохион байгуулахаар тогтов.

5. Тайлангийн талаар ОУИТБС-ын Ажлын албатай хамтран нийтэд мэдээлж ажиллахыг Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанд даалгав.

6. Тайлан хэлэлцсэнтэй холбогдуулан гишүүдийн хуралдаан дээр гаргасан саналыг Ажлын хэсэгт танилцуулж, төлөвлөгөө болон бусад асуудалд тусган хэрэгжүүлэхээр тогтов.

Б.Долгор: За энэ асуудлаа дуусгаж, дараагийн асуудалдаа орёе.

II. ХЭЛЭЛЦСЭН нь: “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын болон Ерөнхий сайдын захирамжийн төслийн тухай

Б.Долгор: Тогтоолын төсөл, танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа гээд тогтоолын төслийг танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/

За энэ төсөлтэй холбоотойгоор асуух асуулттай хүн байна уу? Байхгүй бол саналтай хүн байна уу?

Г.Уранцоож: Тогтоолын 7 дугаар зүйлийн санаачилгад нэмж оруулах гэдэг дээр “Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу орон нутагтай байгуулсан гэрээ, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахтай холбогдсон үнэлгээ, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах болон хайгуулын ажлын явц” зэргийг нэмж оруулж өгөөчээ гэсэн саналтай байна. За та бүхэн тэр орон нутагтай байгуулсан гэрээ гэдгийг мэдэж байгаа байх, харин тэр нийгмийн сөрөг нөлөөллийн үнэлгээ гэдэг дээр нэмэлт тайлбар өгөхөд одоо бол ийм үнэлгээ хийгдээд эхэлсэн байгаа бөгөөд үүнийг яаж хийхийг 2010 онд батлагдсан БОНБНУ хийх аргачилсан зааварт нарийн тусгаж өгсөн байгаа. Хоёрдугаарт 11.1 дээр яг үүнтэйгээ холбогдуулаад “Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутагтай байгуулсан гэрээ, түүнийг хэрэгжилт” гэж нэмж оруулж өгөөчээ гэсэн саналтай байна. Гуравдугаарт, 13.5 гэж нэмэлт заалт оруулмаар байна. Үүнд: “ОУИТБС-ын жилийн тайланг хэлэлцэн дүгнэсний дараа Ашигт малтмалын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.11-д заасан шаардлагыг хангаж, стратегийн ач холбогдол бүхий ордод тооцогдох шаардлагыг хангасан ордуудын тухай мэдээллийг Засгийн газарт өгч, энэ талаар олон нийтэд ил тод мэдээлж байх” гэж оруулах саналтай байна. Дөрөвдүгээрт, 13.6 “ОУИТБС-ын тайлангаа хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөөгүй аж ахуйн нэгжүүдэд Ашигт малтмалын тухай хуулийн 66 дугаар зүйлийн дагуу хуулийн хариуцлага тооцох ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргаа, ИТХ, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хэрэгжүүлж, үр дүнг тухайн ондоо багтаан олон нийтэд мэдээлж байх” гэж оруулах саналтай байна. Тавдугаарт, 14.1 гэсэн заалт дээр “иргэний нийгмийн байгууллага, иргэдэд өгсөн хандив” гэж оруулах саналтай байна. Яагаад гэхээр компаниуд иргэдэд гэсэн нэрийн дор хахуул өгөх явдал байдаг.

П.Эрдэнэжаргал: Үндэсний зөвлөл болон орон нутагт байгуулагдах дэд зөвлөлтэй холбоотойгоор журам гаргах гэсэн саналтай байна. Бид үнэхээр Үндэсний зөвлөлийн хуралд идэвхтэй оролцох боломжгүй байна. Жишээ нь өнөөдрийн хурлын материалыг өчигдөр 5 цагт авсан. Ингэхлээр материалтай тухтай танилцах, үр ашигтай санал хэлээд суух боломж байхгүй байна. Тэр Засгийн газрын байгууллагуудын хийсэн танилцуулгуудыг урьдчилж авмаар байна.

Тэгээд өнөөдрийн хуралдааны даргыг өч төчнөөн минут хүлээгээд, сүүлдээ ирэх боломжгүй болохоор орлоод сууж байгаа нь энэ Үндэсний зөвлөлийн ажлыг нэр төдий болгож байна. Олон улсад бид шаардлагыг хангасан орон гэж рекламдах дуртай мөртлөө Үндэсний зөвлөлийн ажил ийм л маягтай явагдаж байна, 6 сард гарсан тайланг бид 4 сарын дараа хэлэлцэж байна. Тэгэхээр энэ бүгдийг цэгцлэх нэг тусдаа журам боловсруулах үүргийг энэ тогтоолдоо оруулаад, тэр журмаа мөрдөөд явбал яасан юм бэ гэсэн саналтай байна.

Н.Баярсайхан: Төлөөллийн бүрэлдэхүүн дээр санал хэлэх гэсэн юм. Тэр 1.1, 1.2 нь Засгийн газрын байгууллага гэсэн үг, үүнээс нийт 11 төлөөлөгч, харин компани, иргэний нийгмийг тус бүр 5 төлөөлөл төлөөлж байна. Тэгэхээр энэ харьцааны хувьд анхаараарах, тэгш оролцоотой гэсэн баланс алдагдах вий гэсэн болгоомжлол төрж байна. За 8 дугаар заалт дээр тэр лицензийг компанитай нь худалддаг болсон асуудлыг яаж оруулах вэ? үүнийг нэг бодолцож үзээчээ гэсэн санал байна. Дээр нь их л олон заалт дээр нийтэд мэдээлэх гэж тэмдэглэсэн байна. Гэтэл яаж нийтэд ил тод мэдээлэх вэ гэдэг аргачлалыг нь гаргаж өгч, зааж өгөх хэрэгтэй. Тухайлбал, хуульд дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд ил тод мэдээлнэ гэж заасан байдаг. Гэтэл ажлын албанаас зүгээр нэг сонин дээр гаргачихаад түүнийгээ мэдээлсэн гээд байдаг. Үүнийг бүр нарийвчилж хэвлээд, тухайн сум орон нутгаар тараана гэх ч юмуу их нарийн аргачлалыг нь зааж өгөхгүй бол ерөнхий нэр томъёо яваад энэ ажил маань хэрэгжихгүй байх талтай байна. За 80 дугаар тогтоол нь хүчингүй болж байгаа юм байна. Тэр 80 дугаар тогтоолын дагуу бол аймгуудад салбар зөвлөл байгуулагдах тухай заасан байдаг. Гэтэл бүх аймгуудад салбар зөвлөл байгуулагдаагүй, цөөхөн хэдэн аймгуудад байгуулагдсан боловч үйл ажиллагаа явуулаагүй байх жишээтэй. Тиймээс энэ 80 дугаар тогтоолын хэрэгжилтын үнэлгээг хийх хэрэгтэй. За 11 дүгээр заалтад аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг өгсөн байна. Үүн дээр нэмээд ИТХ-д бас тодорхой чи үүрэг даалгавар өгмөөр байна. Дэд зөвлөл байгуулна гэж байна. Яг тэр уул уурхай төвлөрсөн сумдад дэд зөвлөл байгуулмаар байна. Үндэсний зөвлөл хурлаа тогтмолжуулах, хурлаар хэлэлцэх материалыг урьдчилж авах шаардлагатай байна. Орон нутгийн түвшинд энгийн малчин иргэн энэ тайланг уншдаг, ойлгодог, хэлэлцдэг баймаар байна.

Ч.Раднаа: 14.1 заалтад санхүүгийн аудитчлагдсан гэсэн байна, үүнийг аудит хийх гэж оруулах нь зүйтэй байх. Хоёрдугаарт Төсвийн тухай хууль батлагдвал ерөөсөө тэр хандив гэдгийг тас хориглож байгаа. Тиймээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны гэсэн энэ заалтаа дахиж нэг хардаг юмуу, эсхүл тэр хууль батлагдахыг түр харзнах хэрэгтэй гэж бодож байна.

Д.Батхуяг: Бид эрх зүйн орчноо сайн судлахгүй бол дараа нь бас дахиад хүндрэл гарах вий. Хоёрдугаарт, хүмүүсийн санал хэлж байгааг сонсоод байхаар бид энэ эдийн засгийн хөгжилд гол хувь нэмэр оруулж байгаа хувийн хэвшлийнхнийгээ хэтэрхий дарамтлаад байх вий, тэднийг илүү урамшуулах талын бодлого баримтлах хэрэгтэй. Санаачлага аятайхан хэрэгжээд яваа зүйлээ үргэлжлүүлээд, дутагдлаа засаад явах хэрэгтэй байна.

Н.Алгаа: Үнэхээр үндэсний зөвлөл жилд 1 удаа хуралдаж байна. Тэгээд нэг хуралдахдаа их олон асуудал хэлэлцэж байгаа учраас асуудлыг тухтай авч үзэх ч боломж олдохгүй байна. Тэгэхээр хурлаараа хэлэлцэх асуудлыг илүү чиглэл чиглэлээр нь хувааж хэлэлцэх, тухайлбал, бодлогын асуудлыг нэг тусад нь,

тайланг батлах асуудлыг нэг тусад нь ч юмуу. Орон нутагтай байгуулсан гэрээ гэж ярьж байна. Яг тэр гэрээ нь хэд байгаа юм, байгуулагдсан гэрээ байгаа юмуу, байгуулагдаагүй бол байгуулагдаагүй гэрээг одоо ярих биш байгуулагдахгүй байгаа шалтгааныг тодруулах хэрэгтэй байх. Гол хэлэх гээд байгаа санаа нь энэ тогтоол дээр нээх олон зүйл оруулдаг, тэр нь эргээд хэрэгжихгүй үр ашиггүй байх вий. За хоёрдугаарт, яг юуг нь ил тод болгох вэ гэдгийг ялгаж салгах зааг хэрэгтэй, үнэхээр бүх нийтийн тусын тулд шаардлагатай зүйлсээ ил тод болгох хэрэгтэй, компанийн зүгээс бас ил болгохгүй нууцлах зүйл гэж байна. Хуулийн ажлын хэсэгт нилээд найдлага тавьж байна, Үндэсний зөвлөлөөс тэдэнд нилээд сайн дэмжлэг үзүүлж ажиллах хэрэгтэй гэсэн саналтай байна.

Д.Энхбат: 10.3-т туслан гүйцэтгэгч гэж байна, үүнийг хасах саналтай байна. Учир нь яамны зүгээс туслан гүйцэтгэгчийн тайланг бид огт баталдаггүй. За тэр тайланг хянан шалгаж гэсэн байна. Сумдын түвшинд ерөөсөө хянан шалгаж байгаа нь мэргэжлийн хяналтын байгууллага. Тиймээс мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хянан, шалгаж гэж оруулах саналтай байна.

Б.Долгор: За баярлалаа. Хүмүүсийн хэлсэн саналыг ажлын хэсгээр хэлэлцэж, үүн дээр ажиллая. Энэ тогтоолыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсний дараагаар батална. Аль аль талууд маань саналаа хэллээ. Тэгэхээр эдгээр саналуудыг хооронд нь уялдуулах гарцаагүй хэрэгтэй бөгөөд эрх зүйн орчиндоо нийцсэн саналыг тусгаж оруулна. Тэр төсвийн тухай хуулийн тухайд яг одоогоор бол батлагдаагүй байгаа боловч бид энэ тогтоолын төслийг Засгийн газрын хурлаар оруулах үед батлагдаж магадгүй юм. Тиймээс тэр үед нь бас хуулийн орчиндоо нийцүүлье.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын болон Ерөнхий сайдын захирамжийн төслийг дэмжиж, хуралдаан дээр гишүүдийн гаргасан саналыг тусган зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэхээр тогтов.

Б.Долгор: За энэ асуудлаа дуусгаж, дараагийн асуудалдаа оръё. Э.Сумъяа танилцуулна.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх 2011 оны 12 дугаар сараас 2013 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийн тухай

Э.Сумъяа: Үндэсний зөвлөлийн гишүүдийн оройн амгаланг айлтгая. Төлөвлөгөөний төслийг та бүхэнд тараасан. Урьд нь бид ажлаа 1 жилээр төлөвлөдөг байсан бол энэ удаад 2 жилээр төлөвлөсөн. Тухайн оны төлөвлөгөөг жил бүр ажлын хэсгээрээ хэлэлцээд Үндэсний зөвлөлийн даргаараа батлуулаад явах ийм ерөнхий зарчим баримталсан байгаа гээд төлөвлөгөөний төслийг танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав./

Б.Долгор: За саналтай хүн байна уу?

Н.Алгаа: Төлөвлөгөө гэж нэрлэмээргүй байна. Үндсэн чиглэл гэж батлаад ажлын алба нь үндсэн чиглэлдээ тулгуурлаад жил бүрийн төлөвлөгөөгөө боловсруулаад батлуулаад явах нь зүйтэй байх.

П.Эрдэнэжаргал: 2 санал байна. Ерөнхийдөө энэ санаачилгыг хэрэгжүүлээд 5 жил боллоо. Баталгаажуулалтаа ч бас хийлгүүлчихсэн. Тэгэхээр энэ ондоо багтаагаад үндэсний хэмжээний хурал, уулзалт хийх гэсэн саналтай байна. Хоёрдугаарт, эрх зүйн орчныг бүрдүүлэх гэдэг дээр тусгай хууль гаргаад тэр нь дэмжигдэх нь үү үгүй юу? Тэгэхээр одоогийн тэр Ашигт малтмалын тухай хуулиндаа нэмэлт, өөрчлөлт оруулаад илүү өргөтгөөд явбал яасан юм гэсэн саналтай байна. Үндэсний зөвлөлийн гишүүд жилд 1 хуралддаг учраас мэдээллээс хол байгаа. Ажлын хэсэг их олон хуралддаг. Тиймээс ажлын хэсгийн хурлаар ямар асуудал хэлэлцэв, ямар шийдвэрт хүрэв гээд тэр мэдээллийг бидэнд явуулж байгааг гэсэн саналтай байна.

Ч.Раднаа. Дөрөв дэх хэсэгт маягтаар гаргаж, аудитчлагдсан байна гэжээ, үүнийг нэг тайлбарлаад өгнө үү?

Ш.Цолмон: Жил бүр төрийн байгууллагууд ил тод байдлын тайланг тогтсон маягтын дагуу гаргадаг. Харин тэр гаргасан тайланг санхүүгийн хувьд аудитлагдсан гэдэг баталгааг гаргах ажлыг хэлээд байгаа юм.

Л.Нямсамбуу: Нэгдүгээрт, аудиторын өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлуудыг энэ төлөвлөгөөнд оруулах. Хоёрдугаарт, энэ нь Үндэсний зөвлөлийн төлөвлөгөө юмуу ажлын хэсгийн төлөвлөгөө юмуу гэдэг нь ялгагдахгүй байна. За зарим нь тухайлбал Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалд “цаг үеийн асуудлууд” гэх мэт тоо бөглөх гэсэн юмуу, хэрэггүй хэсгүүд байна. Дээрээс нь 21 дээр хуралдааны дэгтэй холбоотой зүйлсийг төлөвлөгөөнд оруулсан байна. 28, 29 дээр ажлын хэсгийн ажлыг мөн дэгтэй холбоотой зүйлсийг оруулсан байна. Тэгэхээр иймэрхүү зүйлс зөндөө харагдаж байна. Нэг их замбараагүй, давтагдсан, задарсан байгаа хэсгүүдийг дахиж нэг нягтлаад 2-3 жилийн төлөвлөгөө учраас илүү тоймчилсон, бүлэглэсэн байдлаар төлөвлөөд тухайн үед нь тодотгоод явах саналтай байна.

Д.Батхуяг: 38 буюу тогтолцоог бий болгох гэдэг дээр Зоригт, Батхуяг хэсэн байна. Үүнийг нэг эргэж харахгүй бол Ашигт малтмалын газар бол хэрэгжүүлэгч агентлаг учраас дараа нь тогтолцоо бий болгоогүй гээд над дээр асуудал гарах вий. Төлөвлөгөө - гээд олон ажил жагсаасан байна л даа. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэх санхүүгийн бололцоо байгаа юу? Санхүүгийн багц дүн байна уу?

Э.Сумъяа: Зардлын хувьд дараахь зүйл хэлэе. Нэгдүгээрт, аудитын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Хоёрдугаарт, ажлын хэсгийн буюу сургалт, сурталчилгааны зардлыг Дэлхийн банкны Итгэлийн сангаас гаргаж байгаа. 250,000 ам.долларыг 2013 оны 4 дүгээр сар хүртэл зарцуулахаар тусламжийн гэрээг байгуулаад байгаа. Гуравдугаарт, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 7 чиглэлийн ажлыг хэрэгжүүлэхээр 500,000 еврогийн төсөл хэрэгжих гэж байна. Дөрөвдүгээрт, Үндэсний зөвлөл болон Ажлын хэсгийн гишүүд нь бүгд орон тооны бус, тэдгээр хүмүүстэй холбоотой гарч байгаа зардлыг Засгийн газрын зүгээс гаргаж буй зардал гэж тооцож явдаг.

Д.Батхуяг: За бид гаднаас нилээн дэмжлэг авч байгаа юм байна. Тэгвэл бид яг энэ санаачилгын чиглэлээр 2-3 хүнийг нилээд сайн мэргэшүүлж авах хэрэгтэй. Тэгэхгүй бол нэг л их тусламж үзүүлж байгаа нэрийн дор баахан гадны зөвлөхүүд ирдэг, хамаг зардал нь тэр хүмүүсийн цалинд явдаг, эцэст нь үлдэх юм тун бага байдаг шүү. Тиймээс хэд хэдэн хүнийг маш сайн сургаж авч үлдэх хэрэгтэй шүү.

Ч.Цэндмаа: За би Татварын ерөнхий газрыг төлөөлөн өнөөдрийн хуралдаанд оролцож байна. Татварын ерөнхий газар нь санаачилгын Засгийн газрын тайланг гаргах ажлыг хариуцан ажилладаг. Бид энэ жил уул уурхайн компаниудыг татварын тайлан өгөхдөө энэ ил тод байдлын тайланг хамтад нь вэб хандлагаар, цахим байдлаар тайлагнах ийм программ хангамж байгуулахаар ажиллаж байна. Тэгэхээр энэ ажлыг та бүхэн өөрсдийн төлөвлөгөөндөө оруулж өгөөчээ гэсэн саналтай байна. Хоёрдугаарт, яг ямар компаниуд энэ ил тод байдлын тайланг гаргах вэ гэдэг шалгуур тогтоож өгөхгүй бол манай дээр жишээ нь уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг 2000 орчим аж ахуйн нэгжийн бүртгэл байна. Гэтэл үүнээс цөөхөн хэд нь ил тод байдлын тайлан гаргаж байна. Тиймээс бид яг ямар компани нь ил тод байдлын тайланг гаргах вэ гэдгийг шалгуураар тогтоогоод бүгдийг нь тайлагнуулах нь зүйтэй гэсэн саналтай байна. Гуравдугаарт, энэ төлөвлөгөөний 20 дугаарт газрын тосны гэрээний ил тод байдлыг хангах гэж байна. Гэрээг ил тод болгох юмуу, гэрээний хэрэгжилтийг ил тод болгох юмуу? Үүнийг нэг тодорхой болгох хэрэгтэй. Дээрээс нь зөвхөн газрын тосны гэрээ бус хөрөнгө оруулалтын гэрээ, тогтвортой байдлын гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ зэргийг бас үүнд оруулж өгөх гэсэн саналтай байна.

Г.Жавхлантөгс: Мэдээллийг олон нийтэд түгээх тухайд манай компанийн хувьд жишээ нь мэдээллийн төвүүдийг байгуулж ажиллаж байгаа, үүн шиг санаачилгын ийм төвүүдийг сумдад байгуулаад иргэдэд мэдээллээ түгээж болох юм гэсэн саналтай байна.

Н.Баярсайхан: За энэ санаачилгын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд илүү буулгаж ажилламаар байгаа юм. За манай ТАН эвсэл, Нээлттэй нийгэм форумаас санаачилаад эхний удаад Ханбогд, Цогтцэций сумын түвшинд ил тод байдлын нэгтгэлийн тайлан гаргаж үзэх гэж байгаа, Улаанбаатар аудит корпорацитай гэрээ байгуулаад явж байна. Тиймээс ийм ажлыг илүү өргөжүүлэх талаар энэ төлөвлөгөөнд тусгаж өгмөөр байна. Сумын түвшинд биш юм гэхэд гол гол аймгуудад тайланг гаргаж, хэлэлцдэг баймаар байна. За дээрээс нь бүсийн чуулган хийнэ гэсэн байна. Өмнө нь бид ийм чуулга уулзалт хийж байсан. Төдийлөн иргэд, иргэний нийгэм идэвхтэй оролцож чаддаггүй. Тиймээс аймаг аймгийн дэд зөвлөлийг илүү чадавхжуулаад аймаг тус бүрдээ уулзалт, хэлэлцүүлэг хийгээд явах ажлыг төлөвлөгөөндөө оруулж өгөх гэсэн саналтай байна.

Г.Уранцоож: Төлөвлөгөө дээр маш олон сургалтуудыг төлөвлөсөн байна. Жишээ нь Дэлхийн банкны санхүүжилтээр, ЕСБХБ-ны санхүүжилтээр гээд. Эдгээр сургалтууд хоорондоо давхцах вий. ДБ болон ЕСБХБ-наас явуулж буй сургалтуудыг хооронд нь уялдуулах, давхцуулахгүй байх талаас нь анхаарах хэрэгтэй. За санаачилгыг илүү орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх зорилгоор жишээлбэл ДБ-ны санхүүжилтээр олон бүсийн уулзалтуудыг төлөвлөсөн байна. Үүнийг бүсийн гэхээсээ илүү яг тэр уурхай төвлөрсөн орон нутагт нь хийхээр төлөвлөвөл зүгээр байх. 17 дээр миний түрүүний дурьдсан нийгмийн сөрөг

нөлөөллийг буруулах ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилт, гаргасан зардлыг нийтэд мэдээлэх гэж оруулах саналтай байна. 19 дээр иргэний нийгмийн байгууллага, иргэдэд өгсөн хандив, тусламжийн тайланг гаргаж, нийтэд мэдээлэх арга зүйн асуудал гэж нэмж оруулах саналтай байна. 25 дээр тайлангийн мөрөөр стратегийн ач холбогдол бүхий ордын шаардлагыг шинээр хангаж байгаа ордуудын талаар Засгийн газарт өргөн мэдүүлэх асуудал гэж оруулж өгөх саналтай байна.

Б.Долгор: За баярлалаа. Өнөөдрийн хуралд ЕСБХБ-ны төслийн ахлах зөвлөх, дотоодын зөвлөхүүд маань оролцож байгаа. Та бүхний саяны гаргасан саналуудыг зөвлөхүүд маань өөрсдийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж ажиллах байхаа. Тэгээд та бүхний хэлсэн саналуудыг тусгаад, ажлын төлөвлөгөөгөө дахин боловсруулалт хийж дэмжих саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх 2011 оны 12 дугаар сараас 2013 оны төлөвлөгөөний төсөлд Үндэсний зөвлөлийн гишүүдийн саналыг тусган төлөвлөгөөг дэмжихээр тогтов.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх 2011 оны 12 дугаар сараас 2013 оны төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн төлөвлөгөөг боловсруулж, Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэн Үндэсний зөвлөлийн даргаар батлуулж, хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг Үндэсний зөвлөлд танилцуулж байхыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор нарт хариуцуулав.

Б.Долгор: За дараагийн асуудалдаа орье.

Ү. ХЭЛЭЛЦСЭН нь: 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Үндэсний зөвлөлийн хуралдааны шийдвэрийн дагуу авсан арга хэмжээний талаар сонсох мэдээллүүд

Б.Баатарцогт: За та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе гэж мэндчилээд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохиосон ажлын танилцуулга хийв. /Танилцуулгыг хавсаргав./

Б.Долгор: За баярлалаа. Асуух асуулт байна уу?

Н.Алгаа: Хуулийн этгээдэд арга хэмжээ авсан уу, албан тушаалтанд арга хэмжээ авсан уу?

Б.Баатарцогт: Хуулийн этгээдэд арга хэмжээ авсан.

Б.Долгор: За одоо Батхуяг даргын мэдээллийг сонсоё.

Д.Батхуяг: Түрүүнд асуудлаа танилцуулахдаа нэгтгээд танилцуулсан байгаа. Асуулт байвал хариулая.

Н.Баярсайхан: 2009 оны нэгтгэлийн тайлан дээр Ашигт малтмалын газар нь 60 сая төгрөгийн хандив компаниудаас аваад ойгоо тэмдэглэсэн гэж байгаа. Дээрээс нь зөрүү гарсан байна лээ. Энэ ямар учиртай юм бэ? Хууль хэрэгжүүлэх ажлыг хариуцсан агентлаг нь хандив авахаар ажил ер нь хэр зэрэг үр дүнтэй байх вэ?

Д.Батхуяг: Тантай санал нэг байна. Ер нь бол энэ хандив өгдөг, авдаг асуудал сүүлийн гурван жилд эрс багасаж байгаа. Бид үүн дээр анхаарч ажиллая.

Б.Долгор: Та бүхэн асууж байсан, ямар хариуцлага тооцдог юм бэ гээд. Бид бас зүгээр суугаагүй, сая Мэргэжлийн хяналтын ерөнхий газар ямар арга хэмжээ авч, хариуцлага тооцсон талаараа танилцууллаа.

ШИЙДВЭРЛЭСЭН нь 1. Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-т заасны дагуу ОУИТБС-ын тайлан гаргаагүй компаниудын талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнгийн тухай Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Уул уурхайн хэлтсийн дарга Б.Баатарцогтын мэдээллийг сонсож, үр дүнтэй ажилласныг тэмдэглэж, энэ асуудлыг цаашид Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын байнгын анхааралд байлгахаар тогтов.

2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийг олборлосон ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулсан, улс болон орон нутагт оруулсан орлого (тайлангийн Засгийн газрын гаргасан 2008 оны мэдээ), улс болон орон нутагт төлсөн татвар, төлбөр (компанийн 2008 оны мэдээ)-тэй уялдуулан шалгасан дүн, цаашид авах арга хэмжээний тухай Ашигт малтмалын газрын дарга Д.Батхуягийн мэдээллийг сонсож, энэ ажлыг цаашид жил бүр уламжлан хэрэгжүүлэхээр тогтов.

Б.Долгор: За дараагийн асуудалдаа орье.

Ү. ХЭЛЭЛЦСЭН нь: Засгийн газар болон компаниудын ОУИТБС-ын 2010 оны тайлан гаргах ажлын явцын тухай.

Ш.Цолмон: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе гэж мэндчилээд танилцуулга хийв. /Танилцуулгыг хавсаргав./

Б.Долгор: За асуух асуулт байна уу?

П.Эрдэнэжаргал: Би сайн ойлгосонгүй, Засгийн газрын тайлан 61 компаниар л гарсан юмуу?

Ш.Цолмон: Засгийн газрын тайлан 477 компаниар гарсан. Үүнээс 50 сая төгрөгнөөс дээш татвар, төлбөр, хураамж төлсөн 150 компани аудитын нэгтгэлд орсон байгаа. Энэ тайланд орсон 61 компанийн татвар, төлбөрийн тайлан Засгийн газрын тайланд орсон ч, компаниуд өөрсдөө тайлан гаргаагүй байгаа. Үүнийг нөхөн гаргуулж байна.

Н.Алгаа: Татварын ерөнхий газар түрүүнд мэдээлэхдээ 2000 компани уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа гэлээ. Гэтэл яг ашиглалтын лиценз эзэмшдэг нь 1000 орчим компани байдаг, үүний 30 хувь нь барилгын

материалын түүхий эд олборлодог байх жишээтэй. Тэгэхээр бид энэ тоонуудаа Үндэсний хэмжээнд нэгтгэх хэрэгтэй байна.

Д.Батхуяг: Хайгуулын лицензтэй нь 2000 орчим, ашиглалтын лицензтэй нь 1216 компани байдаг. Ер нь энэ статистик тоогоо хэдүүлээ хамтраад нэгдсэн ойлголттой болоё. Манай газар энэ тооны талаархи мэдээллээ гаргаж өгөө.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.ОУИТБС-ын 2010 оны тайлангаа гаргаагүй байгаа компаниудын нэрсийг төвийн өдөр тутмын хэвлэлд гаргахыг ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмонд даалгав.

2. Тайлан гаргаагүй компаниудын тухай судалгааг 2011 оны 7 дугаар сарын 1-нээр тасалбар болгон гаргаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулахаар Ашигт малтмалын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэхийг Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмонд даалгав.

3. Засгийн газрын 2010 оны ОУИТБС-ын нэгдсэн тайланд мэдээгээ ирүүлээгүй төрийн захиргааны зарим байгууллагуудын удирдлагад үр дүнгийн гэрээний дагуу анхааруулга өгөх арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Үндэсний зөвлөлийн орлогч дарга Д.Зоригт, Сангийн сайд, Үндэсний зөвлөлийн гишүүн С.Баярцогт нарт даалгав.

4.Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын судалгаа хийж, тоо мэдээг нарийвчлан гаргаж мэдээлэхийг Ашигт малтмалын газрын дарга Д.Батхуягт даалгав.

Хуралдаан 19 цаг 40 минутанд өндөрлөв.

Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга



Б.Долгор

Хуралдааны тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны ажилтан



Б.Дэлгэрмаа